



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар 8.3.1, 8.4, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх хэсэг, "Босго үнэ шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бичиг хэргийн материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан ажиллахыг Үнэлгээний хороо (Т.Мөнхтуул)-нд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Захиргаа, удирдлагын газар (Л.Намхайноров)-т үүрэг болгосугай.

4.Үнэлгээний хороонд ажиллах ажилтнуудын "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл"-ийг гаргуулан байгууллагын ЭБАТ-д бүртгүүлж, худалдан авах ажиллагаатай холбогдох баримт бичгээр архивын нэгж үүсгэж, холбогдох албан тушаалтад хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Долгион)-д үүрэг болгосугай.

ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.УРАНЗАЯА



142022 01017

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20.02.2022 оны 02 дугаар сарын 11. -ны
өдрийн 17 дугаар тушаалын хавсралт



**БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Т.Мөнхтуул (ЭЭХХЗГ, ЭБХ-ийн дарга)

Гишүүд:

Д.Бямбадорж (ЭЭХХЗГ, ЭҮХ-ийн дарга)

Б.Батжаргал (Эрүүл мэндийн технологи
инновацийн хамтын ажиллагааны хүрээлэн
НҮТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн)

Т.Отгонтөгс (Сэтгэлд мөнхрөх үйлс ТББ-ын
зохицуулагч)

Нарийн бичгийн дарга:

М.Долгион (ЭЭХХЗГ, ЭАБТСГ-ын мэргэжилтэн)